



БАГШ БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛ

МУБИС - ийн докторант Ч.Цолмончимэ

Abstract

In the 21st century all countries of world are agreed and put attention on that 'Education is the motive power of development'. In other words by developed countries experience the educational level of each population is showing its central power of determining core of the social and economic development.

Same as country society is always being developed and changed, the education is being changed, too.

As shown by last experiences to improve developing speed, it is necessary to change educational system comprehensively based on scientific researches.

In other way at the beginning of the 21st century the world is becoming into humane, gracious society and economic system based on knowledge; it is being done re-engineering based on computer and information communicative new technology. Also it is being risen the needs of all stages of education with teaching status and role. All these aspects are rising to become the defender of global economy and each national democracy.

With this in high developed countries, such as USA, England, Netherlands, Japan, the role of teacher-education is broadened and serial researches are done about this direction.

According to this historic problem following topics are important for today:


- *To do research on nowadays situation of teacher-education and to evaluate it*
- *To choose an expedient way in future implementation*

Удиртгал

Манайд өнгөрсөн зууны 10-аад оноос орчин үеийн шинэ боловсролын тогтолцоо, сургалтын агуулгыг бий болгож хөгжүүлэхдээ тэр үеийн Орос, хожим нь Зөвлөлтийн боловсролын тогтолцоог бүхэлд нь дууриалгаж тогтоосон юм. Дараа дараагийн жилүүдэд ч боловсролын тогтолцоог хөгжүүлж шинэчлэхдээ дэлхий нийтийн /голдуу европын/ хандлагыг харж ирсэн байдаг.

Монгол улсын шууд авч хэрэглэсэн тэр үеийн Орос, Зөвлөлтийн боловсролын тогтолцоо нь гарал үүслээрээ эртний Франц, хожим нь Германаар дамжиж ирсэн европын сонгодог, академик боловсролын тогтолцоо бөгөөд дэвшилттэй тал нь түүний сургалтын агуулга дахь онолын түвшин их өндөр гэх ба өнөөдөр хөгжлөөрөө тэргүүлэгч АНУ, Япон зэрэг орнууд энэ боловсролын тогтолцоог их үнэлж, сонирхон судалж байна.

Picture No.1





Мөн дурьдан буй цаг үед нийгэмд нэг үзэл суртал, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо үйлчилж байхад агуулгыг хатуу тогтоосон нэг маягийн стандартаар дээрээс тогтоож өгдөг, түүнийг сургууль боловсролын байгууллагын түвшинд өөрчилж сайжруулах боломжоор хомс байсан төдийгүй үйлдвэрлэлийн эрчимгүй технологид тулгуурлаж байв.

1990-ээд оны эхнээс нийгэмд үүссэн боловсролын шинэ хэрэгцээг хуучин агуулга, бүтцээр хэрэгжүүлэх боломжгүй байсан, нөгөө талаар гадаад түшиг тулгуур болж ирсэн ЗХУ, социалист систем задран унаж тэр үеийн **“ах дүү”** орнууд барууны боловсролын тогтолцоог баримжаалах болсон зэрэг нь боловсролын тогтолцоог англи маягийн тогтолцоонд оруулж, олон түвшний сургалтыг залгамж сайтай явуулах нөхцөл бүрдүүлэх ажлыг зохион байгуулах шаардлага гарав.

Энэ үед хийгдэж байсан өөрчлөлт шинэчлэлт нь монголын боловсролын тогтолцоонд оршиж байсан дутагдалтай талыг засч сайжруулах, түүний агуулга, сургалтын зарчмыг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн либеральчлах далбаан дор явагдаж байсан боловч үйл явцад өрөөсгөлөөр хандах, үлс орны нийгэм, эдийн засгийн амьдралд тэр үед буй болоод байсан нөхцөл байдал, түүний цаашдын хөгжлийн чиг хандлагыг дутуу харгалзах явдал нийтлэг гарсан.

1990-ээд оны эхээр байгуулагдсан их сургуулиуд нь харьцангуй эрх мэдэлтэй, хариуцлагатай, бие даасан үйл ажиллагаа явуулдаг сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн цогцолборууд бөгөөд бусад түвшний сургуулиуд ч төвлөрсөн удирдлагын үеийн олон эрх мэдлийг өөртөө авсан учир бүх түвшний сургуулийн удирдлага нь сургуулийн эдийн засаг, материаллаг баазыг бэхжүүлэх, багшлах болон эрдэм шинжилгээний боловсон хүчнээр хангах, сургалт – судалгаа - үйлдвэрлэлийг хоршсон байдлаар сургуулийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, хэрэглэгч - зах зээл олох, бэлтгэсэн мэргэжилтэнээ борлуулах өргөн хүрээнд сургуулийг удирдах чадвар дадал, мэдлэгтэй байх шаардлага гарч ирж байна.

Гэтэл дээд, дунд боловсрол олгодог сургуулиудын удирдлагын үйл ажиллагаанд төлөвлөлт - зах зээл судлал – сургалт – судалгаа - үйлдвэрлэлийн борлуулалт гэсэн бүх дамжлагыг багтаасан бүрэн бие даасан үйл ажиллагаа дутагдалтай байгаа бөгөөд ийм чадвар, дадал бий болгоход удирдах ажилтнаас тусгай бэлтгэлийг шаардах юм. Иймд энэ чиглэлээр тусгайлан мэргэшсэн удирдлагыг бэлтгэх явдал ХХ зууны сүүлийн 10 жилийн монголын боловсролын нэг зангилаа асуудал болсон. Энэ асуудлыг дэс дараатайгаар шийдвэрлэсээр байна.

Дээрх түүхэн хандлагатай холбоотойгоор боловсролын салбарт нарийвчилсан судалгааг явуулж, Монгол дахь багш боловсролын одоогийн төлөв байдалд зохих дүн шинжилгээ хийж үзэв.

Зорилго

Монгол дахь багш боловсролын дахин дизайнчлал (redesigning)-тай холбоотойгоор багш боловсролын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, зохих үнэлэлт гаргахад оршино.

Судалгааны арга

Судалгааг бичгээр санал асуулга авч нээлттэй хэлбэрээр хийсэн. Арга нь давтамжийг тоолох болон бүлэглэх, чанарын үнэлгээ хийх.

Өнөөдөр Багш хүн ямар байх вэ? Тухайн улс орны ёс суртахууны имиж төлөөлөл үү? Эсвэл зан суртахууны төлөөлөл үү? Ядуурлын эсрэг тэмцэгч дайчин мөн үү? Глобал эдийн засгийн тулгуур үү? зэрэг асуудал тулгарч байна. Ялангуяа боловсролын зорилго өөрчлөгдөхийн хамт багш бэлтгэх болон багшийн имиж тасралтгүй өөрчлөгдөж байна.

Шинжлэх ухаан, техник технологийн дэвшил, өрсөлдөх өндөр чадавх нь хүний хөгжилтэй, хүний хөгжил нь боловсролын хөгжилтэй, боловсролын хөгжил нь багшийн хөгжилтэй чухал холбоотой юм¹.

Зураг 1



¹ W.E.Cashin (1998) “Student Ratings of Teaching” I.D.E.A pp 28



Иймд боловсролын салбарт багш боловсролын тухай асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлага гарч байгаа юм.

2007 оны байдлаар бүх шатны боловсролын байгууллагад 34286 багш ажиллаж байв. Үүний 78 хувь нь эмэгтэйчүүд. Багш нарын 30 шахам хувь нь 29 хүртэлх насны залуучууд байгаа нь нэг талаас манай салбарт эрч хүчтэй, шинэлэг сэтгэлгээтэй хойч үеийн залгамж халаа бэлтгэгдэж байгааг, нөгөө талаас энэ залуучуудаа туршлагажуулахад ихээхэн анхаарах ёстойг илтгэж буй тоон үзүүлэлт юм. Мөн нийт багш нарын дунд мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь 47-д хүрч өссөн нь илүү чанартай боловсрол эзэмшүүлэх хүний нөөц өсч байгааг харуулж байна.

1990-ээд онд бий болсон боловсролын шинэ тогтолцоог бэхжүүлж, түүнийг бүрэн таньж, хөгжих таатай нөхцөлийг хангахын тулд Монгол улсад боловсрол судлалын шинжлэх ухааныг /эдукология/ шинэ дээд шатанд шинээр үүсгэн хөгжүүлэх шаардлагатай болсон юм.

Үүнтэй холбоотойгоор орчин цагийн багш ямар байх ёстой вэ?

1. Өөрийгөө тасралтгүй хөгжүүлж, сургалтын идэвхтэй, бүтээлч аргуудыг эзэмшсэн.
2. Боловсролын зорилго, агуулга, аргазүй, үнэлгээг төгс ойлгосон.
3. Хүн төрөлхтний болон монголчуудын бүтээсэн соёл,

иргэншлийн үнэт зүйлс, өв уламжлалыг нь түгээн дэлгэрүүлэгч

4. Мэдээллийн технологийг чадамгай ашигладаг, олон эх сурвалжаас авсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан мэдлэгийг хамтран бүтээгч, шинийг санаачлагч
5. Бие даан сурч, ажиллах, амьдрах чадвар бүхий иргэнийг төлөвшүүлэхэд сонирхлын бүлгүүд, олон нийтийн оролцоог эрхэмлэгч, түүнийг чиглүүлэн зохицуулагч байх шаардлагатай болж байна.

Бид энд орчин цагийн багш ямар байх ёстойгоос эхлээд өнөөгийн багш нар багш боловсрол, мэдлэгт суурилсан эдийн засаг дахь багш боловсролын талаар ямар мэдлэг, мэдээлэлтэй байгаа, мөн зах зээлийн үеийн сургалт, боловсролыг хэрхэн үнэлж байгаа талаар судалгаа авсан болно.

Санал асуулгыг МУБИС-ийн Багшийн сургууль болон Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 5 сургууль (111, 21, 79, 48, Хонхорын 88), Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль, Чингэлтэй дүүргийн 1 сургууль (39), Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолбор сургууль, Төв аймгийн ахлах болон дунд сургуулийн нийт 300 багшаас авсан болно. Судалгаанд оролцогчдын 70 гаруй хувь нь эмэгтэй багш нар байсан бөгөөд 60 орчим хувь нь 5-аас дээш жил багшилсан багш нар байв.

Санал асуулга нийт 9 асуулттай. Эдгээр асуултуудаар дараах зүйлийг илрүүлэхийг оролдлоо.

Хүснэгт 1

ДД	Асуултууд	Юуг илрүүлэх
1	Зах зээлийн эдийн засгийн үеийн боловсрол ямар байгаасай гэж хүсэж байна вэ?	Өнөөгийн нийгмийн боловсролыг хэрхэн үнэлдэг болон мэдлэгт суурилсан эдийн засгийн талаарх мэдлэг байгаа эсэхийг илрүүлнэ
2	Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсрол гэж та юуг ойлгож байна вэ?	Багш боловсролын талаарх мэдлэгийг тандъя
3	Зах зээлийн эдийн засагт ямар хүчин зүйлс чухал вэ?	Зах зээлийн эдийн засаг, мэдлэгт суурилсан эдийн засгийн мэдлэгийг илрүүлнэ
4	Зах зээлийн эдийн засгийн үеийн сургалт ямар байгаасай, ямар шаардлага тавигдах ёстой гэж үзэж байна вэ?	Сургалтын шаардлагын тухай мэдлэгийг илрүүлнэ
5	Зах зээлийн үеийн багш боловсролын хөтөлбөрт зайлшгүй тусгагдах асуудалд юуг анхаарах вэ?	Багш боловсролын хөтөлбөрт голлон анхаарах асуудлуудыг тодруулъя
6	Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсролын хөтөлбөрийн агуулга ямар байх ёстой гэж та үзэж байна вэ?	Багш боловсролын хөтөлбөрийн агуулгад тусгагдах зүйлийг тодруулъя
7	Та суралцах онол аргазүйн ямар зарчмыг баримталдаг вэ? Энэ чиглэлээр та юу хийдэг вэ?	Багш нар өөрийгөө тасралтгүй хөгжүүлж чадаж буй эсэхийг илрүүлнэ
8	Сурах чадварт эерэгээр нөлөөлөхийн тулд ямар бодлогыг баримтлах нь чухал вэ?	Багш нарын заах арга, арга технологийн мэдлэгийг тандъя
9	Орчин цагийн багш гэж таныхаар хэн бэ?	Орчин цагийн багш нь мэдлэгт суурилсан эдийн засаг дахь багш боловсролыг эзэмшсэн мэргэжилтэн бие хүн гэдэгтэй санал нийлэх эсэхийг тандъя




Зах зээлийн эдийн засгийн үеийн боловсрол ямар байгаасай гэж хүсэж байна вэ?



Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсрол гэж та юуг ойлгож байна вэ?



Зах зээлийн эдийн засагт ямар хүчин зүйлс чухал вэ?







Зах зээлийн эдийн засгийн үеийн сургалт ямар байгаасай, ямар шаардлага тавигдах ёстой гэж үзэж байна вэ?



Зах зээлийн үеийн багш боловсролын хөтөлбөрт зайлшгүй тусгагдах асуудал




Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсролын хөтөлбөрийн агуулга ямар байх ёстой гэж та үзэж байна вэ?







Та суралцах онол арга зүйн ямар зарчмыг баримталдаг вэ? Энэ чиглэлээр та юу хийдэг вэ?



Сурах чадварт эерэгээр нөлөөлөхийн тулд ямар бодлогыг баримтлах нь чухал вэ?



Орчин цагийн багш гэж таныхаар хэн бэ?





Хүснэгт 2

Санал асуулгын боловсруулалт:

дд	Асуултууд	Дүгнэлт
1	Зах зээлийн эдийн засгийн үеийн боловсрол ямар байгаасай гэж хүсэж байна вэ?	Өрсөлдөх чадвартай болон чанартай, шалгуур өндөртэй, шаталсан төлбөртэй, зах зээлийн эрэлтэд нийцсэн гэсэн хариултууд нэлээд өндөр хувьтай гарсан бол мэдэхгүй болон боловсролтой байсны үр дүн гарахгүй байна гэсэн хариултууд ч нэлээдгүй байлаа. Эндээс харахад, багш нар зах зээлийн үеийн боловсролын гол шалгуурыг нэрлэж байгаа боловч оновчтой мэдлэг хараахан байхгүй байна гэж үзлээ. Мөн боловсрол болон сургалтын тухай тодорхой заагтай хариултыг өгөхгүй байгаа байдал ажиглагдаж байна.
2	Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсрол гэж та юуг ойлгож байна вэ?	Хөрвөх чадвартай болон цогц чадамж бүхий, нэр хүндтэй гэсэн хариултуудыг нэлээд өндөр хувиар өгсөн байна. Мөн багш боловсролыг тодорхойлох хариултууд гарахгүй байгаа нь багш боловсролын талаарх мэдлэг, мэдээлэл багш нарт бага байгааг илтгэж байна.
3	Зах зээлийн эдийн засагт ямар хүчин зүйлс чухал вэ?	Багш нарын цалин хөлсний асуудал гэсэн хариултыг маш өндөр хувьтай өгсөн нь өнөөгийн монголын багш нарын нийгмийн асуудал, тэр дундаа цалин хөлс, урамшууллын оновчтой систем төлөвшөөгүй байгаа нь илт байна. Мөн өндөр чанартай боловсрол, төрийн зөв бодлого, өрсөлдөөн гэсэн хариултууд дараагийн хувийг эзлэж байгаа нь багш нарт мэдлэгт суурилсан эдийн засаг дахь боловсролд чухал байр суурь эзлэх асуудлуудыг хөндөж байгаа нь энэ талаар багш нарт мэдлэг, мэдээлэл байгааг харуулж байна.
4	Зах зээлийн эдийн засгийн үеийн сургалт ямар байгаасай, ямар шаардлага тавигдах ёстой гэж үзэж байна вэ?	Чанартай, техник технологид суурилсан, мэдлэгт суурилсан, хэрэгцээг хангасан гэсэн хариултууд өндөр хувьтай өгөгдсөн байна. Эндээс өнөөгийн нийгмийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг мэдэрч байна гэж үзлээ.
5	Зах зээлийн үеийн багш боловсролын хөтөлбөрт зайлшгүй тусгагдах асуудалд юуг анхаарах вэ?	Жич: Судалгаанд эхний удаад Багш боловсролын талаар багш нар хангалтгүй мэдээлэлтэй байна гэсэн дүгнэлт гарсан учир дараагийн асуултуудыг тавих үндэслэл байхгүй болсон. Иймд багш боловсролын талаар бид товч танилцуулга хийж, мэдээлэл өгсний дараа асуулгын 2 дахь шатыг явуулсан болно. Ингэхэд багш боловсролын хөтөлбөрт голлон анхаарах асуудлуудыг багш нар нэрлэж, энэ талаар тодорхой ойлголттой болсон байлаа.
6	Зах зээлийн эдийн засаг дахь багш боловсролын хөтөлбөрийн агуулга ямар байх ёстой гэж та үзэж байна вэ?	Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэгийг олгох, чанартай хүртээмжтэй цогц байдлаар, харилцаа, ёс суртахууны зан төлөвийн тухай гэсэн хариултууд өндөр хувьтай өгсөн байна. Эндээс үзэхэд хөтөлбөрийн агуулгад байх ёстой асуудлуудыг нэрлэж байгаа мэт боловч энэ нь угтаа багш нар өөртөө нэн шаардлагатай, дутагдаж буй мэдлэгээ нэрлэж байна гэж үзэж байна.
7	Та суралцах онол арга зүйн ямар зарчмыг баримталдаг вэ? Энэ чиглэлээр та юу хийдэг вэ?	Мэргэжлийн семинар курст хамрагдах, орчин үеийн бүтээлч сэтгэлгээний аргуудаас, практикт суурилсан гэсэн хариултууд өндөр хувьтай гарсан байгаагаас сурахуйн онол аргазүйн мэдлэг хомс байгаа нь харагдаж байна. Мөн өөрийгөө хөгжүүлэх талаар багш нар дорвитой зүйл хийхгүй байна.
8	Сурах чадварт эерэгээр нөлөөлөхийн тулд ямар бодлогыг баримтлах нь чухал вэ?	Зорилгоо ухамсарлан бие дааж сурах, уламжлал шинэчлэлийг хослуулсан, хөхүүлэн дэмжих, үлгэрлэн дууриалгах, мэдлэг эзэмшсэний ач тусыг таниулах гэсэн хариултуудаас сурах чадварт эерэгээр нөлөөлөх аргыг зөв ойлгож байгаа боловч түүнийг хэрэгжүүлэх арга зүйгээ мэдэхгүй байна гэж үзлээ. Учир нь дээрх 7-р асуултын дүгнэлттэй холбогдон гарна.
9	Орчин цагийн багш гэж таныхаар хэн бэ?	Орчин цагийн багш нь мэдлэгт суурилсан эдийн засаг дахь багш боловсролыг эзэмшсэн мэргэжилтэн бие хүн гэдэгтэй санал нийлж байна гэсэн дүгнэлт гарч байна.

Иймээс багш бэлтгэх, хөгжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, бодлого, зорилтоо хэрэгжүүлэх асуудалд цогцоор хандах нь чухал болов.

**ДҮГНЭЛТ**

Өнөөдөр глобал, мезо, макро, микро түвшинд боловсролыг төгссөн сургууль, авсан дипломоор нь бус хүний амьдралд тэдний эзэмшсэн боловсрол ямар үүрэг гүйцэтгэж байгаагаар нь үнэлдэг болсон. Манай улсын боловсролын салбарт хийгдэж байгаа сүүлийн жилүүдийн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц бодот бэрхшээл саадыг ажмаар даван, бага боловч урагшилсаар байна. Үүний үр дүнд нэг талаас зах зээлийн өрсөлдөөнт нийгмийн шаардлагаар чанартай боловсрол эзэмшихийн төлөө иргэдийн эрмэлзэл улам бүр өсөж байгаа юм. Нөгөө талаас, боловсролын талаар төрөөс явуулж буй бодлого нь боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар үр өгөөжийг нэмэгдүүлж, иргэдээс боловсрол олж авах эдийн засаг, эрхзүйн таатай орчин бүрдүүлэх чигт бас ч багагүй ахиц гаргаж байна гэж үзэж байна.

Өнөөдөр мэдлэгийг шүтэх буюу улс орныхоо хөгжлийн хурдыг тодорхойлогч боловсролд тэргүүн анхаарлаа хандуулах нь мэдлэгт суурилсан эдийн засгийн гол шинж болно. Харин боловсролын тухай асуудлыг хөндөхөд нэн түрүүнд багшлах хөдөлмөр, түүний шинж, багшлах хөдөлмөрийн чиг хандлага, багшлах хөдөлмөрийн нөхцөл, багшид тавигдах шаардлага, багшийн хөдөлмөрийн агуулга, багшийн хөдөлмөрийн үнэлэмж, үнэлгээ, багшийн нөөц зэрэг багшийн хөдөлмөр, үйл ажиллагаа, мэдлэг, чадвар зэрэг асуудлуудыг цогц байдлаар авч үзэх нь зайлшгүй нөхцөл болно. Угтаа энэ нь багш боловсролын асуудлыг судлах тухай ойлголт юм. Гэвч судалгаанаас харахад, багш боловсролын тухай асуудал өнөөдрийн чухал сэдвүүдийн нэг болж буй нь харагдаж байна.

НОМЗҮЙ

1. Н.Бэгз. “Монгол Улсын Боловсрол: Хөгжлийн сургамж ба зууны төсөөлөл” ХХ зууны боловсрол судлал, Уб., 2003
2. Н.Бэгз. 21-р зууны Монголын боловсролын хөгжлийн загвар. /БХЭШБ/ Уб., 2001 № 1.
3. Д.Ванчигсүрэн. “Монголын сургалтын аргазүй, технологийн шинэчлэл” Боловсрол судлал Уб., 2002
4. У.Доёд, Н.Нэргүй. Сургууль соёлын хөгжлийн шинэ хандлага. Уб., 2002
5. Б.Жадамба. “Танхим дахь мэдлэг бүтээх үйл явц” Уб., 2003
6. Л.Жамц. Боловсрол судлалын онол, аргазүйн зарим асуудал. Боловсрол судлаач эрдэмтдийн шилдэг өгүүллийн түүвэр. Уб., 2002
7. З.Мөнхдалай. “Багш боловсролын дахин дизайнчлал” Уб., 2008
8. Монгол Улсын боловсролын салбарын үүсэл хөгжил. Статистикийн эмхтгэл. Уб., 2001
9. Монголын өсвөр үеийнхний хэрэгцээг судалсан судалгааны тайлан. Б., 2001.
10. З.Мөнхдалай. Боловсролын чанарын менежментийн үндсүүд. Уб., 2000
11. З.Мөнхдалай. Багш боловсролын дахин дизайнчлал. Уб., 2008
12. О.Мягмар. Багшийн нэгэн хувилбар. Уб., 2002
13. Ч.Пүрэвдорж. Боловсролын шинэчлэл, хөгжлийн онол аргазүйн асуудал. Уб., 1999
14. Ц.Сумъяа, П.Цэрэндондов нар. Багш боловсролын хөгжил, шинэчлэл. Уб., 2006
15. “Хөгжих цагийн боловсрол”. БСШУЯ “Багш нарын улсын анхдугаар зөвлөгөөний эмхтгэл”, Уб., 2007
16. Чанартай хөтөлбөр-багшийн хөгжил. Сургалт-семинарын материал. Уб., 2001
17. Alan R.Tom. “Redesigning Teacher Education” S.V. New York Press. 1998
18. American Federation of Teachers “Good News/ Bad news for Teacher Salaries” “AFT Survey” (2002)
19. Goodlad, John “A Place Called School”, New York . McGraw-Hill, 1989
20. Ю.А.Конаржевский “Анализ урока” М.2001
21. В.А.Клейнот. Проблемы современной американской школы и пути их решения. Спб., 1996
22. MacKinnon, A, and G.Erickson. 1992 “The roles of foundational disciplines in Teacher Education” London: Falmer Press
23. K.A.Meyer (1999) “Faculty Workload Studies: Perspective, Needs, and Future Directions” ASHE-ERIC. Report, 26 Washington
24. National Board for Professional Teaching Standards “Press Release” (Sep. 2004), Arlington, UA
25. В.В.Ренкин “Развивающее обучение и учебная деятельность” Рига: 1998
26. “Teachers for Our Nation’s School” San Francisco: Jossey-Bass Publishers., 1990
27. W.E.Cashin (1998) “Student Ratings of Teaching” I.D.E.A